



АНУ-д бизнесээ хөгжүүлье

Яагаад АНУ-д хөрөнгө оруулалт хийнэ гэж?

Бизнесээ хөгжүүлж өргөжүүлэх газраар АНУ-ыг сонгож буй компаниудын тоо дэлхий дээр улам бүр өссөөр байна. Энэ нь ч учиртай юм. АНУ бол дэлхий дээрхи хөрөнгө оруулалтын хамгийн таатай орчинг бүрдүүлсэн орнуудын нэг мөн. Үүнд:

- Авьяаслаг ажиллах хүчин
- Ашигтай хэрэглэгчдийн зах зээл
- Судалгаа, хөгжлийн томоохон бааз суурь
- Оюуны өмчийн эрхийг хамгаалах сайн тогтолцоо
- Ил тод, урьдчилан хэлэх боломжтой эрхзүйн тогтолцоо
- Сайн хөгжсөн дэд бүтэц
- Чадалтай хангамжийн систем

SelectUSA

АНУ-д бизнесээ хөгжүүлэх сонирхолтой хүмүүс одоо SelectUSA буюу “АНУ-ыг сонго” гэсэн хүчтэй шинэ түнштэй боллоо. Үүнийг Ерөнхийлөгч Обама 2011 онд анх удаа санаачилсан ба энэ нь бизнесийн хөрөнгө оруулалтыг ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх гол хөдөлгүүр болгох үүднээс хөхүүлэн дэмжиж, хөнгөвчлөх зорилготой АНУ-ын холбооны муж улсуудын хэмжээнд хэрэгжүүлж буй анхны хүчин чармайлт юм. Энэхүү санаачлагыг АНУ-ын Худалдааны Яамнаас хэрэгжүүлж буй бөгөөд АНУ-ын холбооны агентлаг, газруудын хөрөнгө оруулалттай холбоотой нөөц бололцоог зохицуулдаг. SelectUSA нь олон улсын хөрөнгө оруулалтын хамтын нийгэмлэгийн хувьд мэдээллийн дүн шинжилгээний газар, хөрөнгө оруулагчдын хувьд эрх ашгаа хамгаалах, санал гомдлоо илгээж хандах газар харин АНУ-ын хот, муж, бүсүүдийн хувьд зөвлөгч нь байх юм. Газар нутгийн хувьд төвийг сахисан байдлыг хатуу чанд мөрдөх ба Америкийн аль нэгэн газар нутаг, байршилийг нөгөө газраас нь илүүд үзэн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх бодлого барихгүй.

SelectUSA бол олон улсын болон дотоодын пүүс компаниудыг өсөн дэвжиж АНУ-д хөрөнгө оруулахад нь тус улсын хүрээнд туслан дэмжих цорын ганц газар юм. Мөн түүнчлэн өөрсдийн нутаг оронд бизнесийн хөрөнгө оруулалт татах зорилготой Эдийн засгийн хөгжлийн байгууллагуудтай (ЭЗХБ) хамтран ажилладаг билээ.

SelectUSA нь АНУ дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр бүхий л хүч чадлаа дайчлан ажиллаж байна. АНУ дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ \$2.3 триллион ба зөвхөн 2011 он гэхэд л энэ тоо \$220 тэрбумд хүрээд байгаа урьдчилсан мэдээ байна.

Олон улсын хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн хувьд мэдээллийн дүн шинжилгээний газар
SelectUSA боломжит хөрөнгө оруулагчдыг АНУ-ын хот, муж, бүс нутгуудын ЭЗХБ-уудтай холбоход туслана. Мөн түүнчлэн АНУ-д үйл ажиллагаа явуулж буй бизнесүүдэд зориулсан буцалтгүй тусламж, өөр бусад тусламжийн хөтөлбөр гэх мэт холбооны хэмжээний хөтөлбөр, үйлчилгээний талаархи мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангадаг юм.

Хөрөнгө оруулагчдын хувьд эрх ашгаа хамгаалах, санал гомдлоо илгээх газар

SelectUSA бол одоо хэрэгжиж байгаа, цаашид хэрэгжих, мөн хүлээгдэж буй хөрөнгө оруулалттай холбоотой холбооны хууль тогтоомж, хөтөлбөр, үйл ажиллагааны талаархи асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх газар юм. SelectUSA-тай хамтран ажилласнаар хөрөнгө оруулагчид АНУ-ын хууль дүрмийг хэрхэн мөрдөх талаар илүү сайн ойлголттой болно.

АНУ-ын хот, муж, бүсүүдийн зөвлөгч

АНУ-ын хот, муж, бүс нутгууд бол бизнесийн хөрөнгө оруулалтын төслүүд эрхлэх, хөрөнгө оруулалт татах хүчирхэг өв уламжлалтай. SelectUSA нь АНУ-ын ЭЗХБ-уудад шинээр гадаадад шууд хөрөнгө оруулалт хийх гэж буй газруудтай адил тэгш өрсөлдөх боломжоор хангахад туслах юм. Одоо SelectUSA-ын тусламжаар ЭЗХБ-үүд АНУ-д үндэсний хэмжээнд хөрөнгө оруулалтыг татах, авч үлдэх, хөгжүүлэхэд туслах зөвлөгчтэй болж байна гэсэн үг юм.

SelectUSA-тай холбоо бариарай

SelectUSA болон үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах бол SelectUSA.gov цахим хуудсаар зочилно уу. Мөн (202) 482-6800 утсаар бидэнтэй холбогдоорой.

“АНУ бол гадаадын пүүс компаниудын хувьд хөрөнгө оруулалт хийхэд маш тохиромжтой газар ба энэ нь манай нээлттэй бөгөөд хүчтэй эдийн засаг, үр бүтээлтэй ажиллах хүчин, шинэчлэл, аж ахуй эрхлэх өвөрмөц соёл, гайхалтай сайн их дээд сургуулиуд, мөн ил тод байдал, хамгаалалт, зохиогчийн эрх, хууль журмаар сайн хамгаалсан бизнесийн орчинтой нь холбоотой билээ.”

- Ерөнхийлөгч Барак Обама
2011 оны 6 сарын 20